

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 78.8 хувь нь зорилтот үр дүнд хүрсэн, үүний 98.6 хувь нь тодорхой хэмжээгээр үр өгөөжөө өгч эхэлсэн байна.

АУДИТЫН КОД: ХӨА-2024/26-20-ШТА-ГА

Хөвсгөл аймаг
2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар

Утас: 99979050 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран

Утас: 99389927 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА



Тайланг бэлтгэсэн:

Хөвсгөл аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор

А.Эрдэнэбаатар

Аудитын менежер

Б.Тэгшдэлгэр

Ахлах аудитор

Г.Ичинхорлоо

Аудитор

Н.Гүрбазар

Л.Мандахнаран

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл гарвал
70384043 дугаарын утас,
70383793 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ: Мөрөн сум Аймгийн
ЗДТГ-ын “А” корпус 3
давхар

Цахим хаяг:

audit.mn/?page_id=579

2024 оны 07 дугаар сар

Товчилсон үгийн тайлбар

Аудитын тайлан баталгаажуулах тушаал, хавсралт

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөөлөгчдийн саналаар баталж байна.

1.1. Малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 161.9 сая төгрөгийн эх үүсвэрийг олох боломжийг алдсан байна.

1.2. Шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөөлөгчдийн саналаар баталж байна.

Бүлэг 2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 78.8 хувь нь зорилтот үр дүнд хүрсэн байна.

2.1 ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний тусгай нөхцөлөөр чанарын баталгаат хугацааны барьцаа, алдангийн талаар тодорхой тусгаагүй, худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж ажиллаагүй байна.

2.2 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 78.8 хувь нь зорилтот үр дүнд хүрсэн байна.

2.3 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 729.6 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

Бүлэг 3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 3,474.0 сая төгрөгийн хөрөнгө нягтлан бодох бүртгэл тусгаагүй байна.

3.1 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаагаас ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, хяналттай холбоотой зөрчил жил бүр давтагдсаар байна.

3.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 3,474.0 сая төгрөгийн хөрөнгө нягтлан бодох бүртгэл тусгаагүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Зөрчлийн нэгтгэл

Товчилсон үгийн тайлбар

МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХөТАГ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ТӨЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ХШУДАХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ТБОНӨБАУХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ХАА	Худалдан авах ажиллагаа
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
АМАТЗШ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
ТАХ	Төсөл арга хэмжээ
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
ШГБ	Шууд гэрээ байгуулах
ШХА	Шууд худалдан авалт
ОНО	Олон нийтийн оролцоотой



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 26/25

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны “Эрх үүрэг шилжүүлэх тухай” А/102 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын 1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Архангай аймаг дахь Төрийн аудитын газар, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Хөвсгөл аймгийн Засаг дарга, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газар, Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв, Мөрөн сумын Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

3. “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Г.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторовн 2024 оны 07 сарын 05 өдрийн 285 дугаартай тушаалын хоёрдугаар хэвсрэлт

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2023 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ” ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ТОГТООСОН
ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

№	Төлбөрийн акт, Албан шаардлагын утга	Хариуцах байгууллага	Төлбөрийн акт, албан шаардлагын дугаар
1	Төлбөр барагдуулах тухай	“Бошголсон” ХХК	91/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
2	Төлбөр барагдуулах тухай	Ти Эйч Ти Эн Эрчим” ХХК	92/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
3	Зөрчил арилгах тухай	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	84/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
4	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг дарга	85/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
5	Зөрчил арилгах тухай	Аймгийн Орон нутгийн өмчийн газар	86/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
6	Зөрчил арилгах тухай	Аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-Шинжилгээ, үнэлгээний хэлтэс	87/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
7	Зөрчил арилгах тухай	Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв	88/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
8	Зөрчил арилгах тухай	Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв	89/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
9	Зөрчил арилгах тухай	Мөрөн сумын Засаг даргын тамгын газар	90/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
10	Зөрчил арилгах тухай	Мөрөн сумын Засаг даргын тамгын газар	91/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
11	Зөрчил арилгах тухай	Галт сумын Засаг даргын тамгын газар	92/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА
12	Хариуцлага тооцох албан шаардлага	Мөрөн сумын Засаг даргын тамгын газар	93/2270648/ХӨА-2024/26-20-ШТА-ГА

_____ оооООооо _____

Дүгнэлт гаргах ажлын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл:

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/162, “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны А/100 дугаар тушаал, Монгол улсын Ерөнхий аудитортой байгуулсан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” –д гүйцэтгэлийн аудитыг хийлээ.

Аудитын зорилт:

“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-д Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын баталсан дэд төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг Архангай аймаг дахь Төрийн аудитын газар болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх;
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар 2023 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээ хэрэгжүүлсэн аймгийн Засаг дарга, түүний харьяа Засаг даргын Тамгын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны алба, Санхүү, төрийн сангийн хэлтэс болон хяналтын чиг үүрэг бүхий Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Санхүүгийн хяналт, аудитын алба, Барилга захиалагчийн хяналтын төв, Мөрөн, Түнэл, Тосонцэнгэл, Их-Уул, Тариалан, Шинэ-Идэр, Галт, Жаргалант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга, Засаг даргын тамгын газар, баг хорооны дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон бусад холбогдох төрийн байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулав.

Аудитыг Хөвсгөл аймгийн хэмжээн дэх Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал, хяналт болон холбогдох бусад баримтад тулгуурлан гүйцэтгэв.

Аймаг, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний төсөвт өртгийн 70 хувь буюу 15,405.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 249 төсөл, арга хэмжээг хамруулан аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 300, 3000-3200, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудитын Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудитын Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал” зэргийг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, ярилцлага хийх, асуулга лавлагаа,

тодруулга болон судалгаа авах, баримтад дурдсан мэдээлэлд шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт хийсэн баримт материал, ажлын тайлан, төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд хяналт хийсэн ажлын тайлан болон төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, шийдвэрийг боловсруулав.

Аудитын багийн бүрэлдэхүүн хугацаа:

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, аудитын менежер Б.Тэгшдэлгэр аудитын үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Ичинхорлоо, аудитор Н.Гүрбазар, Л.Мандахнаран нар аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс 7 дугаар сарын 05-ний өдрийн дотор хийж гүйцэтгэлээ.

Аудитад үүссэн хязгаарлалт: Аудитыг гүйцэтгэсэн хугацаа нь Улсын их хурлын сонгуулийн хуулийн хугацаатай давхацсанаас холбогдох зарим албан хаагчид тайлбар тодруулгыг хугацаанд өгч чадахгүй байх зэрэг нөхцөл байдлыг үүсгэсэн.

Ерөнхий мэдээлэл: Монгол Улсын Төсвийн тухай хуульд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Орон нутгийн удирдлага, улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод, хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-аар зохицуулж байна.

Орон нутгийн хөгжлийн сан нь Төсвийн тухай хуулийн 60.2-д заасны дагуу дараах эх үүсвэрээс бүрдэж байна. Үүнд:

- орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг,
- ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь,
- олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг,
- татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр
- малын тоо толгойн албан татвар

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай¹ хуулийн 18 дугаар зүйлд Хөвсгөл аймагт ОНХНС болон улсын төсвөөс ОНХС-д олгох орлогын шилжүүлэг, орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих урсгал зарлагын хэмжээг 11,546.7 сая төгрөгөөр баталсан.

УИХ-аас 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр “Монгол улсын 2023 оны төсвийн тухай” хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр орлогын шилжүүлгийн хэмжээг 2,856.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 14,403.3 сая төгрөгөөр баталсан.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Аймгийн 2023 оны төсөвт тодотгол хийх тухай” 7 дугаар тогтоолоор ба аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн санд дараах байдлаар хуваарилж, баталсан байна.

¹ 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан

Хүснэгт №1. ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг хуваарилсан байдал

/сая төгрөгөөр/

№	Аймаг, сумын нэр	ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг	Үүнээс	
			АМАТЗШ	ТА-3 төслөөс олгосон урамшуулал
1	Аймгийн ОНХС	6,681.9	-	-
2	Алаг-Эрдэнэ	194.1	9.0	-
3	Арбулаг	226.6	0.1	26.5
4	Баянзүрх	284.0	-	39.9
5	Бүрэнтогтох	238.9	12.0	32.7
6	Галт	365.7	-	52.8
7	Жаргалант	353.0	-	41.6
8	Их-Уул	220.3	-	26.4
9	Мөрөн	935.5	0.5	109.1
10	Рашаант	225.9	-	33.4
11	Рэнчинлхүмбэ	491.1	1.8	61.8
12	Тариалан	432.9	-	93.8
13	Тосонцэнгэл	193.8	-	23.3
14	Төмөрбулаг	214.5	-	30.6
15	Түнэл	222.4	1.4	30.4
16	Улаан-Уул	456.2	-	65.7
17	Ханх	324.2	-	38.8
18	Хатгал	145.4	-	-
19	Цагааннуур	226.7	0.5	-
20	Цагаан-Уул	461.0	17.6	95.6
21	Цагаан-Үүр	337.0	-	40.5
22	Цэцэрлэг	459.3	19.3	62.8
23	Чандмань өндөр	216.5	-	-
24	Шинэ-Идэр	194.9	-	28.9
25	Эрдэнэбулган	301.5	-	43.0
	ДҮН	14,403.3	62.2	977.4

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт дэмжих, орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, сайн гүйцэтгэлийг нэмэлт хөрөнгө хуваарилах замаар урамшуулах, төслийн удирдлага, хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зэрэг үйл ажиллагааг 2023 оныг дуустал хэрэгжүүлсэн байна. “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс 2023 онд 20 сумын ОНХС-д 977.4 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-аас Хөвсгөл аймгийн 2023 оны төсвийг батлахдаа орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 15 төсөл, арга хэмжээг шилжих хөрөнгө оруулалтаар, 38 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр баталсан байна. Аймгийн төсөвт 2023 оны 7 дугаар сард тодотгол хийж 15 төсөл, арга хэмжээг нэмж баталснаар 53 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр тогтоожээ.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн талаарх иргэдийн мэдээлэл, оролцоог үнэлэх зорилгоор Хөвсгөл аймгийн 262 иргэнээс санал асуулга авч нэгтгэн дүгнэв.

БҮЛЭГ 1:

Шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөвлөгчдийн саналаар баталж байна.

1.1 Малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 161.9 сая төгрөгийн эх үүсвэрийг олох боломжийг алдсан байна.

1.1.1 Хөвсгөл аймгийн Орон нутгийн хөгжлийн санд Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2-т заасан эх үүсвэрээс 2023 онд нийт 19,448.5 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.

Хүснэгтээр харуулбал:

ОНХС-ийн эх үүсвэр

Хүснэгт №2.

Эх үүсвэр	/сая төгрөгөөр/	
	Дүн	Хувийн жин
ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг	13,161.4	68%
Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр 50%	62.1	0.3%
"Тогтвортой амжиргаа-3" төсөл урамшуулал	977.4	5%
Өмнөх оны дансны үлдэгдэл	3425.4	18%
Зарлагыг хэмнэх болон бусад эх үүсвэр	190.4	1%
Малын тоо толгойн албан татвар	1631.8	8%
НИЙТ	19,448.5	100

1.1.2. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох” аргачлалын дагуу тооцож, хуваарилсан байна.

Аймаг, сумын нэр	ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлэг /сая.төг/	Хувь
Аймгийн ОНХС	6,681.8	50
Сумын ОНХС	6,681.8	50
НИЙТ	13,363.8	100

1.1.3 Монгол улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Хөвсгөл аймгийн ОНХС-д 14,403.3 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсанаас тайлант онд Сангийн яамнаас 202.4 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна. Үүнтэй холбоотойгоор аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийг Шинэ-Идэр сумын ОНХС-д 3.0 сая төгрөг, бусад сумдын ОНХС-д 8.0 сая төгрөг, аймгийн ОНХС-д 23.4 сая төгрөгөөр төлөвлөгөөнөөс тус тус дутуу шилжүүлсэн байна.

Сангийн яам ОНХНС-аас Хөвсгөл аймгийн ОНХС-д олгох шилжүүлгийг 3-12 дугаар саруудад баталсан хуваарь болон мөнгөн дүнгийн дагуу шилжүүлээгүй байна. **Тухайлбал:** Сангийн яамнаас 5 дугаар сард 2,015.5 сая төгрөг шилжүүлэхээр төлөвлөснөөс 1,030.7 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.4² дэх заалттай нийцэхгүй байна.

Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д шилжүүлэх орлогыг аймгийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу шилжүүлээгүй байна. **Тухайлбал:** 2023 оны 2,3 дугаар саруудад ОНХНС-аас ирсэн санхүүжилтийг сумдын ОНХС-д хуваарилахгүйгээр 4 дүгээр сард олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 2.5³ дахь заалттай нийцэхгүй байна.

² “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас орон нутгийн хөгжлийн санд тооцож олгох орлогын шилжүүлгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан сар, улирлын хуваарийн дагуу Төсвийн тухай хуулийн 56.3-т заасан нөхцөл байдал үүсээгүй тохиолдолд тухайн сарын төсвийн мэдээ гарсны дараа аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд шилжүүлнэ”

³ “Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилсан орлогын шилжүүлгийг ажлын 3 хоногийн дотор сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд аймаг, нийслэлийн Засаг даргын баталсан сар, улирлын хуваарийн дагуу хуваарилна”

1.1.4. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасны дагуу малын тоо толгойн албан татварыг 2023 онд Хөвсгөл аймгийн 23 сум, 1 тосгон нийт 1,957.0 сая төгрөгөөр төлөвлөж, 1,630.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж ОНХС-ийн эх үүсвэр болгосон байна. Малын тоо толгойн албан татварын орлогын биелэлтийг сум бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Хүснэгтээр харуулбал:

Малын тоо толгойн албан татвар 2023 он
Хүснэгт №3 /сая төгрөгөөр/

№	Сумын нэр	Төлөв	Гүйц	Зөрүү
1	Алаг-Эрдэнэ	100.0	74.7	(25.3)
2	Арбулаг	85.0	77.9	(7.1)
3	Баянзүрх	94.1	62.2	(31.8)
4	Бүрэнтогтох	200.0	191.5	(8.5)
5	Галт	101.5	65.2	(36.3)
6	Рэнчинлхүмбэ	132.5	95.4	(37.1)
7	Төмөрбулаг	212.7	66.1	(146.6)
8	Улаан-Уул	40.0	35.0	(5.0)
9	Ханх	10.0	8.9	(1.1)
10	Хатгал	19.5	19.3	(0.2)
11	Цагааннуур	10.5	9.5	(1.0)
12	Цэцэрлэг	85.5	64.6	(20.9)
13	Шинэ-Идэр	51.0	45.1	(5.9)
	НИЙТ	1,142.2	815.4	(326.8)

Малын тоо толгойн албан татварын төлөвлөсөн орлогыг хүснэгтэд дурдсан сумд 326.8 сая төгрөгөөр тасалсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1⁴ дэх заалттай нийцэхгүй байна.

Малын тоо толгойн албан татвараас бүрдүүлсэн орлогыг дараах сумууд бүрэн ОНХС-ийн эх үүсвэр болгоогүй байна. Үүнд:

- Баянзүрх сум 19.9 сая төгрөгөөр,
- Рэнчинлхүмбэ сум 1.0 сая төгрөгөөр,
- Төмөрбулаг сум 0.5 сая төгрөгөөр,
- Ханх сум 1.1 сая төгрөгөөр,
- Хатгал тосгон 0.2 сая төгрөгөөр

Нийт 22.7 сая төгрөгөөр ОНХС-ийн эх үүсвэрт бүрэн төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8⁵ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитад хамрагдсан сумдын малын тоо толгойн албан татварыг төлөвлөсөн байдлыг 2022 оны жилийн эцсийн дүнтэй харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

Малын тоо толгойн албан татварын төлөвлөлт

Хүснэгт №4

/сая төгрөгөөр/

№	Сумын нэр	Төлөвлөх боломжит дүн	2023 оны төлөв.	Зөрүү
1	Их-Уул	162.2	96.5	15.4
2	Түнэл	136.3	60	40.6
3	Тосонцэнгэл	129.1	78	45.9
4	Тариалан	100.5	100.5	1.6
5	Мөрөн	106.4	140	0.6
6	Жаргалант	53.4	48	5.3
	НИЙТ	687.9	526.0	161.9

Зарим сумд малын тоо толгойн албан татвараас орох орлогыг үндэслэлтэй төлөвлөж чадаагүйгээс 161.9 сая төгрөгөөр ОНХС-ийн эх үүсвэр нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

⁴ 41.2.1. хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;

⁵ малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна.

Сангийн яамнаас ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу аймагт олгоогүйгээс аймаг сумдыг хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлж ажиллаагүй, малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 161.9 сая төгрөгийн эх үүсвэрийг олох боломжийг алдсан, 22.7 сая төгрөгөөр бүрэн төвлөрүүлж ажиллаагүй зэрэг нь эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг бүрэн дайчлан ажиллаагүйг харуулж байна.

1.2. Шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөөлөгчдийн саналаар баталж байна.

1.2.1 Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө орон нутгийн хөгжлийг дэмжихэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ард иргэдийн саналд үндэслэхээр Төсвийн тухай хуулийн 60.3.6-д⁶, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2⁷-д заасан байна.

Аймаг, сумын ОНХС-г төлөвлөхдөө нийт 45,207 иргэнээс нийт 831 төсөл арга хэмжээний саналыг авсан байна.

ОНХС-ийн үл ажиллагааны журамд заасны дагуу ОНХС-ийн төлөвлөлтийг баг, сум, аймгийн түвшинд хэрэгжүүлснийг үзэхэд дараах байдалтай байна.

Багийн түвшинд ОНХС-ийн төлөвлөлтийн тухайд:

Баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн болон малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгын аргуудаас ашиглан зохион байгуулсан байна. Үүнд:

1. санал асуулгын хуудас - ОНХС гар утасны аппликейшн
2. бүлгийн ярилцлага
3. нээлттэй хэлэлцүүлэх

Сумдын ОНХС-ийн төлөвлөлтийн тухайд:

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр багийн ИТХ-аар хэлэлцэн батлан ирүүлсэн жагсаалтыг сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нэгтгэн эрэмбэлж нэгдсэн жагсаалтыг 7 дугаар сард багтаан боловсруулсан байна.

Нэгдсэн жагсаалтыг боловсруулахдаа сумын хөгжлийн төлөвлөгөө, тухайн сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээ, сумын тэргүүлэх чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Сумдын засаг дарга иргэдийн саналд үндэслэн эрэмбэлэгдсэн төсөл арга хэмжээнүүдийг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн боловч жагсаалтад тусгагдаагүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй 162.4 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээг ИТХ-аас баталж хэрэгжүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.2⁸ дахь заалттай нийцэхгүй байна.

Хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №5 Иргэдийн саналд үндэслээгүй ТАХ

№	Сумын нэр	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/
1	Тариалан	Малын эрүүл мэндийн хамгаалах сургалт сурталчилгаа	4.5
2		Мал эрүүлжүүлэх зардал	4.0
3		Шивэртийн галын гүүр засварлах	15.0

⁶ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх;

8

4		ЕБС-ийн дотуур байрны хатуу эдлэл шинэчлэх	15.0
5		Соёлын төвд шаардлагатай техник хэрэгсэл худалдан авах	14.5
6		400 кват, 160 кват трансформатор авах	39.1
7	Тосонцэнгэл сум	Малын эрүүл мэндийн хамгаалах сургалт сурталчилгаа	5.0
8		6-р багт мал угаалгын ванн барих	9.0
9		Сумын төвийн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх	18.3
10		Зөөврийн тайз худалдан авах	26.0
11		Түнэл Илч хашаан дахь 380 вт 2 шугам шилжүүлэх, талбайг чөлөөлөх	2.0
12		Цагдаагийн кубон засварлах	10.0
Нийт дүн			162.4

Сумдад ОНХС-ын хөрөнгөөр иргэдийн санал аваагүй, эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчил бүрэн арилаагүй байгаа нь сумын ИТХ-ын төлөөлөгчид тухайн хуралдаанд санал оруулж баталдгаас шалтгаалж байна.

Аймгийн ОНХС-ийн төлөвлөлтийн тухайд:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/165 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг нь сум өөрийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүй 182 төсөл, арга хэмжээний жагсаалтыг хүлээн авч эрэмбэлж аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг урьдчилсан жагсаалтаар 48 төсөл арга хэмжээг нэгтгэн эрэмбэлсэн байна.

Гэхдээ Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээс өмнө олон нийтийн оролцоотой төлөвлөх дараах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. **Үүнд:**

- Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулах;
- Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулах;

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.4⁹, 7.5¹⁰ дахь заалтуудыг зөрчсөн байна.

1.2.2 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээ нь Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” болон аймгийн ИТХ-ын Хуралдааны 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн “Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 02 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Аймгийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилтууд болон дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээтэй нийцүүлэн төлөвлөсөн байна.

1.2.3 Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих төсөл, арга хэмжээг ИТХ-д өргөн барьж, батлуулахдаа тухайн шатны Засаг дарга төсөвлөлтийн шаардлагыг хангуулж техник эдийн засгийн үндэслэл зураг, төсөв, эдийн засгийн тооцоо судалгааг хийсэн байх үүрэгтэй.

Аудитаар аймаг, сумдын ОНХС хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний төсөвлөлтийн шаардлага хангуулж төлөвлөсөн эсэхийг хянахад дараах байдалтай байна. Үүнд:

1. Аймаг болон Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3,122.4 сая төгрөгийн 31 төсөл, арга хэмжээнүүдийн ажлын даалгавар, техникийн

⁹ Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.

¹⁰ Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.

тодорхойлолт, зураг, төсөв нь 2023 оны төсөв баталсанаас хойш хийгдсэн байна. /Дэлгэрэнгүй жагсаалтыг тайлангийн хавсралт №1-р харуулав/

2. Зураг, төсөв, ТЭЗҮ хийгдээгүй төсөл арга хэмжээг баталснаас худалдан авах ажиллагааг хуульд заасан хугацаанд зохион байгуулдаггүй,
3. Зураг төсөвгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас гүйцэтгэл зөрүүтэй төсөв хүрдэггүй, зураг төсвийн хооронд зөрүүтэй байдал үүсдэг зэрэг эрсдэлийг бий болгож байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹¹, ТБОНӨБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.8, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3¹²-т заасантай нийцэхгүй байна.

Дээрх зөрчлийг арилгах зөвлөмжийг “Хөвсгөл аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах” гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн боловч хэрэгжилт хангалтгүй байна.

Үүнээс шалтгаалан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний төсөвт өртөг хүрэхгүй байх, худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүйгээс төлөвлөлтийг хууль, журамд заасны дагуу хийхгүй байгаа нь харагдаж байна.

1.2.4 Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 641 төсөл арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.2-т заасан чиг үүрэгтэй нийцэж байгаа эсэхийг хянахад дараах байдалтай байна.

Аймгийн ОНХС-ын тухайд:

График №2



Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 46.4 хувийг дэд бүтэц, зам гүүр, 17.9 хувийг орчны тохижилт ногоон байгууламжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэхээр тусгасан байна.

¹¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹² ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх;

Сумын ОНХС-ын тухайд:

График №3



Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний 34 хувийг дэд бүтэц, зам гүүр, 17 хувийг орчны тохижилт, ногоон байгууламж, 15 хувийг иргэдийн эрүүл мэнд боловсрол, 15 хувийг малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэхээр төлөвлөж баталсан байна.

Аудитад хамрагдсан аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээнүүд нь ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасан чиг үүрэгтэй нийцүүлж төлөвлөсөн байна.

Сумын төсвөөр бие даан хэрэгжүүлэх боломжгүйгээс аймгийн ОНХС-ийн хэрэгжүүлэхээр төлөвлөлтийн шатанд ирүүлсэн санал болон хэрэгжилтийг харьцуулан үзэхэд сум өөрийн төсвөөр хэрэгжүүлж болох төсөл арга хэмжээг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн байна.

Сум өөрийн төсвөөр хэрэгжүүлж болох төсөл арга хэмжээг түүвэрлэн хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6 Сум өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой ТАХ

№	Сумын нэр	ТАХ-ний нэр	Төсөвт өртөг /сая.төг/
1	Мөрөн сум	Ухаалаг худаг гаргах /Мөрөн сум 5-р баг/	40.0
2	Цагааннуур	Цагаан загас үржүүлгийн зөвлөх үйлчилгээ авах /Цагааннуур сум/	10.0
3	Тариалан	"А" зэрэглэлийн 22 ортой Эрүүл мэндийн төвийн барилгын ажлын цахилгааны шугамын трассыг өөрчлөх /Тариалан сум 7-р баг/	19.0
4	Жаргалант	Хүүхдийн 2-р цэцэрлэгийн нүхэн жорлон /нойл/ барих /Жаргалант сум/	5.0
5	Улаан-Уул	Гялаадын намгийн зам засвар арчлалт /Улаан-Уул сум/	19.0
6		Өл, Тоомын давааны зам засвар, арчлалт /Улаан-Уул сум/	19.0
7	Арбулаг	Хүрэн булгийн далангийн зам засвар, арчлалт /Арбулаг сум/	11.0
8	Галт	Ерөнхий боловсролын сургуулийн танхимын засвар /Галт сум/	12.0
9	Түнэл	Дулааны шугам сүлжээний ажил /Түнэл сум/	15.0
10		Цагдаагийн кубон засварлах /Түнэл сум/	10.0
Нийт дүн			150.0

Дээрх төсөл арга хэмжээ нь аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 07 дугаар тогтоол “Тодотгол”-оор баталж хэрэгжүүлсэн нь ИТХ-ын төлөөлөгчид тухайн хуралдаанд санал оруулж баталдаг дээр дурдагдсан зөрчил мөн давтагдаж байна.


ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлт болон журамд заасан чиг үүрэгтэй нийцүүлэн төлөвлөсөн боловч шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөөлөгчдийн саналаар баталж байгаа нь төлөвлөлтийн шаардлага хангахгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 2: Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 78.8 хувь нь зорилтот үр дүнд хүрсэн байна.

2.1. ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний тусгай нөхцөлөөр чанарын баталгаат хугацааны барьцаа, алдангийн талаар тодорхой тусгаагүй, худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж ажиллаагүй байна.

2.1.1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжих 7,534.5 сая төгрөгийн 95 төсөл арга хэмжээ, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 10,927.4 сая төгрөгийн 515 төсөл арга хэмжээ нийт 18,461.8 сая төгрөгийн 610 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэлбэрийг авч үзвэл:

График 3. ОНХС-ийн ХАА-г зохион байгуулсан хэлбэр /сая төгрөгөөр/



Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээний 57.2 хувьд нь худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй буюу шууд худалдан авалтын аргыг ашигласан нь сумдын ОНХС-гийн хөрөнгөөр 20.0 сая төгрөгөөс доош үнийн дүнтэй арга хэмжээг баталж хэрэгжүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр Шинээр хэрэгжихээр баталсан 53 төсөл, арга хэмжээ, шилжих хөрөнгө оруулалтаар баталсан 6 төсөл арга хэмжээ нийт 59 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн ОНӨГ-аас зохион байгуулсан байна.

Худалдан авах ажиллагаа зохион байгуулсан 59 төсөл арга хэмжээнээс 8 төсөл арга хэмжээг 44 багц болгон задалж нийт 95 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Багцаар хуваасан худалдан авах ажиллагааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний багцад хуваасан байдал

№	Багцаар хуваасан төсөл арга хэмжээний нэр	Багцын тоо
1	Виртуал орчин, Дижитал музей бий болгох /Орон Нутгийг Судлах Музей/	2
2	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төвд тоног төхөөрөмж худалдан авах /Цагааннуур сум/	3
3	Сумын төвийн дотор зам засвар, ус зайлуулах хоолойн хамт /Жаргалант сум/	2
4	Өрхийн үйлдвэрлэл дэмжих төвд тоног төхөөрөмж худалдан авах (Мөрөн сум)	4
5	Багийн төвийг эрчим хүчинд холбох /Бүрэнтогтох сум, Туяа баг/ ажлыг	2
6	Аялал жуулчлалын бүс, зам дагуу стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барих /Мөрөн сум /	2
7	“Хамгаалагдсан Хөвсгөл” арга хэмжээний хүрээнд Намнангийн арын постын ажил	2
8	Зураг төсвийн сан	27
	НИЙТ	44

Аудитад хамрагдсан сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний ХАА-г төсөв баталсан үеэс эхлэн зохион байгуулж ажиллаагүйгээс зарим төсөл, арга хэмжээ тайлант онд хэрэгжиж дуусаагүй байна. **Тухайлбал:** Түнэл суманд 9.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Мал угаалгын ванн” барих ажлын ХАА-г 10-р сард зохион байгуулснаас тус ТАХ бүрэн хэрэгжиж дуусаагүй, иргэдэд үр ашгаа өгч эхлээгүй байна. Энэ нь ТБОНӨБАҮХАТХ-ийн 46.1.8¹³ дахь заалттай нийцэхгүй байна.
2. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд чанарын баталгаа, гэрээний хугацаа, алдангийн талаар тодорхой тусгаж өгөөгүй, тухайн ажлыг хүлээлгэн өгснөөс хойш чанарын баталгаатай холбоотой үүсэх харилцаа тодорхойгүй нөхцөлтэй байна. **Тухайлбал:** Түнэл, Тосонцэнгэл, Шинэ-Идэр сумд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын гэрээнд чанарын баталгаат хугацааны барьцааг суутгах асуудлыг огт тусгаагүй, байна. Энэ нь ТБОНӨБАҮХАТХ-ийн 43.6¹⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

Аудитаар илэрсэн зөрчлийн хэмжээ нь материаллаг бус байгаа тул аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажилласан байна гэж дүгнэлээ.

2.1.2 Хөвсгөл аймгийн хэмжээнд 2023 онд 19,448.5 сая төгрөгийн эх үүсвэрийг орон нутгийн хөгжлийн санд бүрдүүлж 15,108.3 сая төгрөгийг зарцуулан 4,340.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Цагаан-Уул Могойн голын 35кВ-ын ЦДАШ-н засвар арчлалт” төсөл арга хэмжээг “Бошголсон” ХХК гүйцэтгэж санхүүжилтийг 100 хувь авсан байхад Хөвсгөл Эрчим хүч ХХК тус ажлын машин механизм, ажиллах хүч, тээврийн зардалд 19.4 сая төгрөгийг ямар нэгэн гэрээ хэлцэлгүйгээр давхардуулан зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул аудитаар давхардсан 19.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлэхээр **төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэв.
2. Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн “Эрдмийн далай цогцолбор сургуулиас Номын өргөө дэлгүүр хүртэл гэрэлтүүлэг, явган замын тохижилт” төсөл арга хэмжээний явган замын хэмжээ зураг төсөвт заагдсан хэмжээнээс 179 м2 дутуу хийгдсэн байхад ажлыг хүлээж авч, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12-т “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно” дахь заалттай нийцэхгүй байна. Тус ажлын зөрүү 6.6 сая төгрөгийг гүйцэтгэгч “Ти Эйч Ти Эн эрчим” ХХК-аар төлүүлэхээр **төлбөрийн акт** тогтоохоор шийдвэрлэв.
3. Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Ухаалаг худгийн тохижилтын ажил төсөл арга хэмжээний зураг төсөвт заасан Долоогоно мод 3 ширхэг, Агч мод 3 ширхэг, Нарс мод 6 ширхэг, нийт 0.8 сая төгрөгийн 12 ширхэг

¹³ барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв батлагдсан даруйд эхлүүлэх;

¹⁴ 43.6.Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болн

модыг суулгаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12-т “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно.” дахь заалттай нийцэхгүй байна. Аудитаар зөрчил арилгах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4. Мөрөн сумын 9,11,12-р баг хөгжлийн төвийн урд байрлах хүүхдийн тоглоомын талбайн тохижилт төсөл арга хэмжээнээс ажлын даалгаварт заасан, талбайн тэмдэг тэмдэглэгээг хийгээгүй, талбайн хажууд 2 ширхэг хогийн сав байршуулаагүй байхад захиалагч ашиглалтад хүлээн авсан нийт 6.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.8.12-т “Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно.” дахь заалттай нийцэхгүй байна. Аудитаар зөрчил арилгах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.
5. Галт сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 4 цэгт шинээр гаргасан гүн өрмийн худгийн ажлын зураг төсөвт тусгагдсан худаг дотор 1.5 метр куб хэмжээтэй цэвэр усны нөөц "нерж" савны оронд 1м3 багтаамжтай хуванцар савыг худаг тус бүрд байршуулсан байхад хүлээн авсан байна. Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэж заасантай нийцэхгүй байгаа тул зөрчил арилгах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авах ажлын хэсэг, улсын комисс, Барилга захиалагчийн хяналт төвийн холбогдох албан хаагчдын хариуцлагагүй байдлаас шалтгаалан төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжээгүй байхад ашиглалтад авч, санхүүжилтийг олгосон байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2.4. “барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлт гаргах бөгөөд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх мэдээллийг цахим системд баталгаажуулсан байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байгаа тул ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг зураг төсвийн дагуу бүрэн хийгдээгүй байхад хүлээн авсан холбогдох албан хаагчдад **сахилгын хариуцлага тооцох албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажилласан боловч ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний тусгай нөхцөлөөр чанарын баталгаат хугацааны барьцаа, гэрээний хугацаа хэтэрсэн тохиолдолд үүсэх харилцаа, алдангийн хувь хэмжээний талаар тодорхой тусгаагүй, худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж ажиллаагүй байна.

2.2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 78.8 хувь нь зорилтот үр дүнд хүрсэн байна.

2.2.1 Хөвсгөл аймгийн 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр нийт 20,503.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 641 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн баталснаас 545 төсөл арга хэмжээнд гэрээ байгуулж, 506 төсөл арга хэмжээг тайланд онд бүрэн хэрэгжүүлж, 33 төсөл

арга хэмжээг дутуу хэрэгжүүлж, 102 төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. Үүнээс харахад:



1. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 78.8 хувь нь зорилтот үр дүнд хүрсэн байна.
2. Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй, төсөл арга хэмжээнүүдийг хянаж үзэхэд дараах нийтлэг шалтгаантай байна. Үүнд:
 - Малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй төлөвлөж, ОНХС-ийн эх

- үүсвэрээр бүрэн төвлөрүүлээгүй,
- Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан,
 - Худалдан авах ажиллагааг төсөв баталсан хугацаанаас эхлэн зохион байгуулаагүйгээс гүйцэтгэгч тендерт оролцоогүй,
 - ТАХ-ний төсөвт өртгийг үндэслэлтэй тооцоолоогүйгээс тендерт гүйцэтгэгч оролцоогүй,
- Тухайлбал:** аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Цагаан-Уул сумын төвийн үерийн далан байгуулах төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 6 удаа, 60.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хатгал тосгонд стандартын шаардлага хангасан ундны усны худаг гаргах” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 5 удаа, 29.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Үүдний вистебулын Гонх” (Нийтийн номын сан, Музей) засвар хийх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 5 удаа, 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Сумын төв дотор зам засвар, арчлалт /Рашаант сум/” төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг 4 удаа тус тус зарласан боловч гүйцэтгэгч оролцоогүйн улмаас тайлант онд хэрэгжээгүй байна.

2.2.2. Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнээс 13,984.8 сая төгрөгийн 506 төсөл арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээнүүдийн төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №8 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилт, үр дүн

/сая төгрөгөөр/


Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Төсөл, арга хэмжээний зорилтод түвшний үр дүнд			
	тоо	гэрээний дүн	хүрсэн ТАХ		хүрээгүй ТАХ	
			тоо	дүн	тоо	дүн
Сумдын ОНХС	455	8,071.2	451	7,890.5	4	180.7
Аймгийн ОНХС	51	5,913.6	48	5,735.8	3	177.8
нийт дүн	506	13,984.8	499	13,626.2	7	358.6

Хүснэгтээс харахад аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 5,735.8 сая төгрөгийн 48 төсөл арга хэмжээ, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 7,890.5 сая төгрөгийн 451 төсөл, арга хэмжээ нийт 13,626.2 сая төгрөгийн 499 төсөл, арга хэмжээ иргэдэд үр өгөөжөө өгч эхэлсэн байна.

Аудитаар аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 3,827.8 сая төгрөгийн төсөл арга хэмжээг түүвэрлэн хянахад дараах байдалтай байна.

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр “Мөрөн сумаас-Хилэнтийн гүүрний чиглэлд 1.5 км хатуу хучилттай авто зам” төсөл арга хэмжээнд тайлант онд 323.8 сая төгрөгийг зарцуулснаар аялал жуулчлалыг бодлогыг дэмжсэн арга хэмжээ болсон байна.
2. Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд 1,069.3 сая төгрөгийн гудамж талбайн гэрэлтүүлэг шинэчлэх, нэмэгдүүлэх төсөл арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Хөвсгөл аймгийн сумын төвүүд бүрэн гэрэлтүүлэгтэй болж, гэмт хэрэг зөрчил буурах, иргэдийн амгалан тайван амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.
3. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр “Эрүүл шүд Эрүүл хүүхэд” арга хэмжээний хүрээнд 133.5 сая төгрөгөөр шүдний рентген аппарат, шүдний иж бүрдлийг сумдад нийлүүлснээр Шинэ-Идэр, Цэцэрлэг, Тариалан, Их-Уул, Жаргалант, Улаан-Уул сумд шүдний өвчлөлийн үзлэг, эмчилгээг сумандаа хийх боломжтой болсон байна.
4. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр “Хоггүй Хөвсгөл” төслийг хэрэгжүүлж 82.7 сая төгрөгөөр Алаг-Эрдэнэ, Бүрэнтогтох, Тосонцэнгэл, Цэцэрлэг, Түнэл, Төмөрбулаг, Эрдэнэбулган сумдад хог пресслэгч төхөөрөмжийг нийлүүлснээр дээрх сумд дахивар бүтээгдэхүүнийг ялгаж авдаг болсон байна.
5. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Улаан-Уул суманд 134.8 сая төгрөгөөр “Автогрейдер”, Галт суманд 164.8 сая төгрөгөөр “50 ковш”, Баянзүрх суманд 198.0 сая төгрөгөөр “дугуйт 210 экскаватор” зэрэг тоног төхөөрөмжийг худалдан авснаар тухайн сумд өөрсдийн нөөц боломжийг ашиглан зам засвар арчлалтыг хийх боломж бүрдсэн байна.
6. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Сод эрдэм сургуулийн баруун талын 1.1 км хатуу хучилттай авто замыг барих ажилд 1,246.0 сая төгрөгийг зарцуулснаар, орчны тоосжилт буурч, Сод-Эрдэм сургуулийн багш, сурагчдын эрүүл ахуй, аюулгүй байдалд бодит үр нөлөө үзүүлсэн байна.
7. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Хоггүй Хөвсгөл төсөл арга хэмжээний хүрээнд 199.8 сая төгрөгөөр хог ангилан ялгах савыг 15 байршилд, батерей цуглуулах савыг 50 байршилд байршуулснаар иргэдийг хогоо ангилан ялгах боломжоор хангасан байна.
8. Их-Уул сумын ОНХС-ийн хөрөнгөөр “мал ариутгалын Дүк автомашин”-ыг 49.9 сая төгрөгөөр худалдан авснаар суманд мал ариутгал, мод усалгаа, гал унтраах зэрэгт ашиглаж байна.
9. Галт сумын ОНХС-ийн хөрөнгөөр 155.3 сая төгрөгийн 4 цэгт гүн өрмийн худгийг гаргах төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр 4 багийн иргэдийн ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулсан байна.
10. Тосонцэнгэл сумын ОНХС-ийн хөрөнгөөр 71.9 сая төгрөгийн 4 багт гүн өрмийн худгийг гаргах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээр 4 багийн иргэдийн ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулсан байна.

Аудитын хүрээнд иргэдээс авсан санал асуулгын дүнгээр “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 онд баталсан хөрөнгөөр хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтууд нь орон нутгийн хөгжлийг дэмжсэн үр дүнтэй ажил болсон уу?”



хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтууд нь орон нутгийн хөгжлийг дэмжсэн үр дүнтэй ажил болсон уу?” гэсэн асуултад иргэдийн 53 хувь нь хангалттай сайн, 44 хувь нь сайн мэдэхгүй байна, 7 хувь нь хангалтгүй гэж үнэлсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 78.8 хувь нь зорилтот үр дүнд хүрсэн, зорилтот үр дүнд хүрсэн нийт 506 төсөл, арга хэмжээнээс 499 төсөл арга хэмжээ буюу 98.6 хувь нь тодорхой хэмжээгээр үр өгөөжөө өгч эхэлсэн байна.

2.3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 729.6 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

2.3.1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авсан 51 төсөл арга хэмжээнээс 46 төсөл арга хэмжээг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж ашиглалтад хүлээн авсан 455 төсөл арга хэмжээнээс 450 төсөл арга хэмжээг зориулалтын дагуу ашиглаж байна. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний ашиглалтын байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний ашиглалт

/сая төгрөгөөр/

Аймаг, сумын нэр	Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийн ашиглалт			
	тоо	гэрээний дүн	Зориулалтын дагуу бүрэн хүчин чадлаар ашиглаж буй ТАХ		Огт ашиглаагүй ТАХ	
			тоо	дүн	тоо	дүн
Сумын ОНХС	455	8,071.2	450	7,907.4	5	163.9
Аймгийн ОНХС	51	5,913.6	46	5,697.2	5	216.4
Нийт дүн	506	13,984.8	496	13,604.6	10	380.3

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнээс 380.3 сая төгрөгийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй байна.

Аудитаар Хөвсгөл аймгийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019-2023 онд хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний үр дүн, ашиглалтыг авч үзэхэд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн дараах төсөл, арга хэмжээ ашиглагдахгүй байна. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №10. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ашиглалтгүй хөрөнгийн жагсаалт

/сая төгрөгөөр/

№	Сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжсэн огноо	Төсөв /сая.төг/	Ашиглахгүй байгаа шалтгаан
Өмнөх онуудад хэрэгжүүлсэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ					
1	Галт	Усан оргилуур	2019	16.9	Зөөврийн ус ашигладаг.
2	Баянзүрх	Бяслагийн үйлдвэрийн байр	2020	28.0	Тоног төхөөрөмж байхгүй.
НИЙТ				44.9	
2023 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ					
1	Аймгийн ОНХС	Фитнесийн тоног төхөөрөмж /Түнэл сум/	2023	30.0	Зориулалтын байх байхгүй.
2	Аймгийн ОНХС	Брэнд бүтээгдэхүүн борлуулах цэг /Тосонцэнгэл сум/	2023	104.0	Иргэдтэй түрээсийн гэрээ байгуулаагүй.
3	Аймгийн ОНХС	"Эрүүл шүд Эрүүл хүүхэд" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх /Улаан-Уул, Жаргалант сумд/	2023	48.5	Шүдний эмчгүй
4	Аймгийн ОНХС	Хоггүй Хөвсгөл төслийн хүрээнд Пресслэгч машин /Тосонцэнгэл, Төмөрбулаг сумд/	2023	20.2	Ашиглагчийг шийдвэрлээгүй.
5	Аймгийн ОНХС	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих /Мөрөн сум/	2023	13.7	Иргэдтэй түрээсийн гэрээ байгуулаагүй.
6	Түнэл	ЭМТ-д шүдний кабинет байгуулах	2023	23.9	Шүдний эмчгүй
7	Тосонцэнгэл	Эко Тосонцэнгэл хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмж худалдан авах	2023	20.0	Эрчим хүчний асуудлыг шийдвэрлээгүй.

8	Мөрөн	Бэлчээрийн худаг	2023	29.9	Хариуцагчийг тодорхойлоогүй.
9	Мөрөн	Төв садны тохижилт	2023	79.9	Хариуцагчийг тодорхойлоогүй.
10	Галт	Мах сүү борлуулах цэгт тоног төхөөрөмж авах	2023	10.0	Ашиглагчийг шийдвэрлээгүй.
ДҮН				380.3	
Нийт дүн				424.2	

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 424.2 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглахгүй, иргэдэд үр өгөөжөө өгөөгүй байгаа нь төлөвлөлтийн шатанд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хэрэгжүүлсний дараах өмчлөл, ашиглалтын дүгнэлтийг хангалтгүй гаргасантай холбоотой байна.

2.3.2. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12¹⁵-д өмчлөгч байгууллага хадгалалт, хамгаалалтыг хариуцахаар заасан.

Аудитаар аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хадгалалт, хамгаалалтын байдлыг хянаж үзлээ.

Хүснэгт №11 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хадгалалт, хамгаалалт алдагдсан ТАХ

№	Сумын нэр	Төсөл, арга хэмжээний нэр	Хэрэгжсэн огноо	Төсөв /сая.төг/	/сая төгрөгөөр/
					Тайлбар
1	Түнэл	Ахмадын өргөөний барилга	2020	50.0	Чанар муудсан.
2	Арбулаг	Буянтын булгийн эх хаших	2020	8.5	Хулгайд алдагдсан
3	Тариалан	Сэлэнгэ голын дээгүүр бярааз барих	2020	7.5	Эвдэрсэн
4	Баянзүрх	Алтрагийн голын гүүр	2021	5.0	Үерт урссан
5	Тосонцэнгэл	Мал угаалгын ДҮК машин	2022	78.0	Хадгалалтын горим алдагдсан.
6	Аймгийн ОНХС	Биеийн тамирын гадна талбайн тохижилт /Дэлгэрмөрөн цогцолбор/	2022	49.6	Хашаа эвдэрсэн.
7	Аймгийн ОНХС	Хүүхэд залуучуудын гурвын эсрэг гурав сагсны талбай барих /Мөрөн сум 7-р баг/	2023	69.8	Хаалга эвдэрсэн, цементэн шал ховхорсон, будаг халцарсан.
8	Их-Уул	Жижиг дунд үйлдвэрлэлийг бүтээгдэхүүн борлуулах худалдааны цэг	2023	37.0	Төлөвлөлтийг алдаатай хийснээс барилгын чанар алдагдаж, хананд цав гарсан.
Нийт дүн				305.4	

Хүснэгтээс харахад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд бий болсон 305.4 сая төгрөгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн чанар байдал хангалтгүй байгаа нь өмчлөгч байгууллагын хадгалалт, хамгаалалт хангалтгүй байгааг харуулж байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хадгалалт хамгаалалт үр дүнг сайжруулах, ашиглалтгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь ашиглах ажлыг зохион байгуулж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт **албан шаардлагаар** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 424.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй, 305.4 сая төгрөгийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан, нийт 729.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт нь орон

¹⁵ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна.

нутгийн хөгжил болон иргэдийг тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болоогүй, ашиглаж эхлээгүй байна.

БҮЛЭГ 3:

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 3,474.0 сая төгрөгийн хөрөнгө нягтлан бодох бүртгэл тусаагүй байна.

3.1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаагаас ОНХС-ийн төлөвлөлт, зарцуулалт, хяналттай холбоотой зөрчил жил бүр давтагдсаар байна.

3.1.1. Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-д Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тухай шатны ИТХ хяналт хэрэгжүүлэхээр заасан байдаг.

Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хийсэн хяналт хангалтгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2¹⁶ дахь заалттай нийцэхгүй, өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тус зөрчилд **албан шаардлага** өгөхөөр шийдвэрлэлээ.

Сумдын ИТХ нь 2023 оны ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүргийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хяналтын үр дүнг тооцож, нийтэд ил тод мэдээлэх ажил хангалтгүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 7 сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд хяналт шалгалт хийсэн байна. “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны эрсдэлд суурилсан хяналтын төлөвлөгөө”-нд аймгийн ОНХС-ын 2023 оны үйл ажиллагаанд нийцлийн аудитаар хийхээр, 9 сумын ТАХ-ний 2022-2023 оны зарцуулалтад хяналт тавьж ажиллахаар төлөвлөсөн байна. Одоогийн байдлаар төлөвлөгөөнд заасан хугацаа болоогүй тул хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9.5¹⁷ нийцэхгүй байна.

Тогтвортой амьжиргаа-3 төслөөс хийсэн жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр Хөвсгөл аймгийн хэмжээнд 71.0 хувиар үнэлэгдсэн байна. Сумдын гүйцэтгэлийн үнэлгээний дэлгэрэнгүйг хавсралт №4-өөр оруулав.

3.2.2 Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлын захиалагчийн дүрэм”-ийн 2.2¹⁸, 2.8¹⁹-д заасны дагуу аймгийн Засаг дарга болон сумдын Засаг дарга нар “Барилга захиалагчийн хяналтын төв”-тэй гэрээ байгуулан захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлсэн байна

¹⁶ Тухайн шатны ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө, оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих

¹⁷ ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ

¹⁸ Барилга байгууламжийн хөрөнгө оруулагч захиалагчийн чиг үүрэг хэрэгжүүлэх этгээдийг байнгын ажиллагаатай, эсхүл тухайн барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгэх хугацаагаар байгуулан ажиллуулах бөгөөд Барилгын тухай хуулийн 37.2-т заасан мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээдээр захиалагчийн чиг үүргийг төлөөлүүлэн хэрэгжүүлж болно.

¹⁹ Захиалагч Барилгын тухай хуулийн 37.1.4-т заасан барилгын үе шатны ажилд тавих хяналтыг хэрэгжүүлэхдээ захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээдийг томилон ажиллуулна.(Энэ заалтыг Засгийн газрын 2018 оны 316 дугаар тогтоолоор нэмсэн)

Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллагаас барилга угсралтын ажлын явцад үе шатны хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, зураг, төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй барилгыг хүлээн авч ашиглалтад оруулсан байна. **Тухайлбал:**

1. Тээлийн амны ногооны талбайн үерийн далангийн их засвар /Тосонцэнгэл сум/

Тус газарт ногоо тариалдаг иргэдийн ногооны талбайг үерээс хамгаалах даланг сэргээн засварлаж, 75 м.кв чулуу цементэн бэхлэлт хийх ажлын даалгавартай боловч ажлыг дутуу гүйцэтгэсэн, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй байхад барилга захиалагчийн хяналтын төв нь НД-35/2023 дугаартай “Захиалагчийн барилгын хяналтын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт” гаргаж, дүгнэлтийн дагуу санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Гүйцэтгэгч компани гүйцэтгэлийн төсвийг дэлгэрэнгүй байдлаар гаргаж, тайлагнаагүйгээс аудитын хугацаанд шийдвэр гаргах боломжгүй нөхцөл үүссэн.

2. Уран дөш хүүхдийн зуслангийн хашаа барих ажил

Уран дөш хүүхдийн зуслангийн 333.3 метр хашааг шинээр барих, будах, эргэдэг хаалга хийх ажлын даалгавартай боловч гүйцэтгэлээр 216 метр хашаа барьсан, будгийн ажлыг хийгээгүй. Барилга захиалагчийн хяналтын төв дүгнэлтдээ будгийн ажлын тухай дурдсан боловч хашааны урт, бусад хийцийн тухай дурдаагүй байна.

3. "Урандөш" хүүхдийн зуслангийн байруудын их засвар

Уран дөш хүүхдийн зуслангийн хуучин 6 шовгорыг засварлах ажлыг гүйцэтгэгч компани баталсан зургийн дагуу гүйцэтгээгүй, явцын шатанд зураг төсөв өөрчлөгдсөн гэх боловч зохиогчоор өөрчлөлтийн дүгнэлт гаргуулаагүй байхад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ байхгүй байхад ДД-40/2023 дугаартай “Захиалагчийн барилгын хяналтын техникийн хяналтын нэгдсэн дүгнэлт” гаргаж, дүгнэлтийн дагуу санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагын зүгээс байнгын ашиглалтад оруулахад тавих хяналт хангалтгүй байгаа Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5 *“барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах”* Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т *“Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна”* гэж заасныг зөрчсөн байна.

Дээрх зураг, төсөв, гүйцэтгэл зөрүүтэй ажлуудад дахин хяналт хэрэгжүүлж, зураг төсвийн зөрүүг магадлан хийж, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

“Барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ нь аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үе шатны хяналтыг хийдэггүй, дүгнэлтийг ерөнхий байдлаар өгдөг, хурлын тэмдэглэлд ажлын явц, гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй тусгадаггүй, аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6. *“Энэ хуулийн 32.1.5, 33.1.23-т зааснаас бусад барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах”* Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан *“Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.1. “Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ”* гэж заасныг хангахгүй байгаа тул тус зөрчилд захиалагчийн хяналтыг хангалтгүй хэрэгжүүлж байгаа зөрчлийг таслан зогсоох **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Захиалагч талаас барилга байгууламж, дэд бүтцийн зураг, төсвийн тооцооллын уялдаа, үнэн зөв байдалд хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэх албан хаагч тодорхойгүй байна.

3.1.3 Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газраас өмнөх онд буюу 2022 оны 6 дугаар сард хийж гүйцэтгэсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” гүйцэтгэлийн аудитаар нийт 1,847.1 сая төгрөгийн зөрчлийг илрүүлэн аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг арилгах цаашид давтан гаргахгүй байх тухай 19 зөвлөмжийг хүргүүлсэн байна. Өмнөх аудитаар өгсөн 5 зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Хүснэгтээр харуулбал:
Хүснэгт №12 Зөвлөмжийн хэрэгжилт

№	Хариуцах албан тушаалтан	Зөвлөмжийн утга	Зөвлөмжийн хэрэгжилт
Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн”- аудит			
1	Аймгийн ИТХ-ын дарга	Аймгийн ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллан, хяналтаар илэрсэн асуудлыг хэлэлцэж үр дүнг нийтэд ил тод мэдээлж байх	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн ТАХ-д тавьсан хяналт хангалтгүй, ИТХ-ын хурлын хуралдаанаар оруулсан мэдээлэл байхгүй байна. Хэрэгжилт: 20 хувь
2		Иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн, Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан чиг үүрэгт нийцсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэлэлцэн батлах	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 22 ТАХ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна. Хэрэгжилт: 0 хувь
3	Орон нутгийн өмчийн газрын дарга	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний ашиглалт, хадгалалт хамгаалалт үр дүнг сайжруулж, ашиглалтгүй байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж ажиллах	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний хүрээнд бий болсон 3,474.0 сая төгрөгийн хөрөнгийг НББ-д тусгаагүй, хадгалалт хамгаалалтын үр дүнг сайжруулах ажлыг зохион байгуулсан боловч одоогоор үр дүнг тооцоогүй байна. Хэрэгжилт: 20 хувь
4	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв, иж бүрэн мэдээлэх.	Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд 66 хувьтай мэдээлсэн байна. Хэрэгжилт: 70 хувь
5	Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга	ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийж нийтэд ил тод мэдээлэх	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнд хяналт шинжилгээ хийж, нийтэд мэдээлээгүй байна. Хэрэгжилт 0 хувь
“Хөвсгөл аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах” аудит			
1	Аймгийн Засаг дарга	Аймгийн ОНХС-ын хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-нийцүүлэн төлөвлөж байх.	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 22 ТАХ нь төсөвлөлтийн шаардлага хангаагүй байна. Хэрэгжилт: 0 хувь

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг тооцож үзэхэд 73.6 хувьтай байна.

Аудитаар зөвлөмжийг хангалтгүй хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлүүдэд **Албан шаардлага** өгөхөөр шийдвэрлэсэн.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Барилга захиалагчийн хяналтын төв”-өөс хийсэн гүйцэтгэлийн хяналт хангалтгүй, аймгийн ИТХ болон аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ээс хяналт хийгээгүй, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь зөрчил давтагдан гарах шалтгаан болсон байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 3,474.0 сая төгрөгийн хөрөнгө нягтлан бодох бүртгэл тусаагүй байна.

3.2.1. Сумдын ОНХС-ийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан маягт аргачлалын дагуу гаргаж, сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн тайланд нэгтгэж тайлагнасан байна.

Аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ нь 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 9.2²⁰-д заасны дагуу сумдаас ирүүлсэн тайланг нэгтгэсэн боловч дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулаагүй байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.3²¹ дахь заалттай нийцэхгүй байна.

3.2.2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүнд 5,151.0 сая төгрөгийн хөрөнгө, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын үр дүнд 6,032.4 сая төгрөгийн хөрөнгө, нийт 11,183.5 сая төгрөгийн хөрөнгө бий болсон байна. Үүнээс 7,709.5 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлж нягтлан бодох бүртгэлд тусгаж тайлагнасан байна.

Аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 3,474.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлэх шийдвэр гараагүй, нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна. /Хавсралт 2-оор харуулав./

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг нягтлан бодох бүртгэлд хөтлөх, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.6. “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэ журамд заасны дагуу шийдвэрлэнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байгаа тул **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.2.3. Удирдлагын мэдээллийн системд Хөвсгөл аймгийн хэмжээнд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 20,539.5 сая төгрөгийн 641 төсөл арга хэмжээнээс 17,761.3 сая төгрөгийн 550 төсөл, арга хэмжээний мэдээллийг бүрэн оруулсан байна.

ХБТХОХ нь аймгийн ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 10.3.2²²-д заасныг баримтлан үнэн зөв, иж бүрэн мэдээлээгүй байна. Сумын ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд зарим сумд дутуу мэдээлсэн байна.

Удирдлагын мэдээллийн системд ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зөрүүтэй мэдээлснийг хүснэгтээр харуулбал:

²⁰ Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана.

²¹ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр гарган, дүгнэлт өгч, цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

²² Аймаг, нийслэл, сум, дүүргийн ОНХС хариуцсан мэргэжилтэн ОНХС-ийн УМС-ийн хэрэгжилт цэсэнд хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн талаарх мэдээллийг ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системд оруулна

Хүснэгт-7

№	Аймаг, сумын нэр	ИТХ-аар баталсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний		Үүнээс:					
				ОНХС-ийн удирдлагын мэдээллийн системд мэдээллийг					
				Бүрэн оруулсан ТАХ-ний		Дутуу оруулсан ТАХ-ний		Огт оруулаагүй ТАХ-ний	
тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн		
0	1	2	3	4	5	6	7	8	9
1	Алаг-Эрдэнэ	32	378.6	26	278.1	-	-	6	100.5
2	Галт	31	632.1	30	602.0	1	30.1		-
3	Жаргалант	21	447.3	19	351.9	2	95.4	0	-
4	Их-Уул	19	421.0	15	364.6	1	15.0	3	41.4
5	Мөрөн	22	1,393.5	19	1,265.5	2	93.0	1	35.0
6	Рэнчинлхүмбэ	31	941.4	22	622.4		-	9	319.0
7	Тосонцэнгэл	23	373.2	9	228.3	3	41.5	11	103.4
8	Төмөрбулаг	26	484.6	25	484.1	1	0.5		-
9	Улаан-Уул	41	589.9	35	537.5	1	6.0	5	46.3
10	Цагаан-Үүр	17	413.8	8	162.8	4	61.0	5	190.0
11	Цэцэрлэг	30	608.8	21	353.8	9	255.0	0	-
12	Шинэ-Идэр	10	274.6	9	252.5	1	22.1		-
13	Эрдэнэбулган	18	336.4	15	296.4	-	-	3	40.0
	сумын дүн	573	11,955.3	505	10,460.2	25	619.5	43	875.6
14	Хөвсгөл аймгийн ОНХС	68	8,584.2	45	7,301.1	1	20.0	22	1,263.1
	НИЙТ ДҮН	641	20,539.5	550	17,761.3	26	639.5	65	2,138.7

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй мэдээлснээс иргэд үнэн зөв мэдээллийг авч чадахгүй байх эрсдэлийг үүсгэж байна.

3.2.4. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэлийг Шилэн дансны цахим хуудсанд ТЕЗ болон 23 сум, 1 тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч олон нийтэд ил, тод үнэн зөв мэдээлсэн байна.

ОНХС-ийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд ил тод мэдээлэх тусдаа цэс байхгүйгээс иргэд мэдээллийг авахад хүндрэлтэй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 3,474.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, удирдлагын мэдээллийн системд төсөл арга хэмжээний мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн зэрэг нь бүртгэлээр тавих хяналт болон мэдээллийн ил тод байдал хангалтгүй байгааг харуулж байна.

Аудитаар нийт 10,804.8 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 26.0 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 7,838.2 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 2,940.6 сая төгрөгийн зөрчилд 12 зөвлөмжийг тус тус хүргүүллээ.

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Сангийн яамнаас ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу аймагт олгоогүйгээс аймаг сумдыг хуваарийн дагуу бүрэн санхүүжүүлж ажиллаагүй, малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 161.9 сая төгрөгийн эх үүсвэрийг олох боломжийг алдсан, 22.7 сая төгрөгөөр бүрэн төвлөрүүлж ажиллаагүй зэрэг нь эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг бүрэн дайчлан ажиллаагүйг харуулж байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлого төлөвлөлт болон журамд заасан чиг үүрэгтэй нийцүүлэн төлөвлөсөн боловч шат шатны ИТХ-ын хуралдаан дээр иргэдийн саналаар эрэмбэлээгүй, зураг төсөв, ТЭЗҮ хийгээгүй төсөл арга хэмжээг төлөөлөгчдийн саналаар баталж байгаа нь төлөвлөлтийн шаардлага хангахгүй байгааг харуулж байна.
3. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажилласан боловч ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний тусгай нөхцөлөөр чанарын баталгаат хугацааны барьцаа, гэрээний хугацаа хэтэрсэн тохиолдолд үүсэх харилцаа, алдангийн хувь хэмжээний талаар тодорхой тусгаагүй, худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулж ажиллаагүй байна.
4. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний 78.8 хувь нь зорилтот үр дүнд хүрсэн, зорилтот үр дүнд хүрсэн нийт 506 төсөл, арга хэмжээнээс 499 төсөл арга хэмжээ буюу 98.6 хувь нь тодорхой хэмжээгээр үр өгөөжөө өгч эхэлсэн байна.
5. Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 424.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглаагүй, 305.4 сая төгрөгийн хөрөнгийн хадгалалт хамгаалалт алдагдсан, нийт 729.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт нь орон нутгийн хөгжил болон иргэдийг тогтвор суурьшилтай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг болоогүй, ашиглаж эхлээгүй байна.
6. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Барилга захиалагчийн хяналтын төв”-өөс хийсэн гүйцэтгэлийн хяналт хангалтгүй, аймгийн ИТХ болон аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ээс хяналт хийгээгүй, аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэхгүй байгаа нь зөрчил давтагдан гарах шалтгаан болсон байна.
7. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний хүрээнд бий болсон 3,474.0 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагад шилжүүлж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, удирдлагын мэдээллийн системд төсөл арга хэмжээний мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн зэрэг нь бүртгэлээр тавих хяналт болон мэдээллийн ил тод байдал хангалтгүй байгааг харуулж байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

1. Иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн, Төсвийн тухай хууль болон холбогдох журамд заасан шаардлагад нийцсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээг хэлэлцэн батлах
2. Сумдын ОНХС-ийн төлөвлөлт, гүйцэтгэлд хийх хяналтыг чанартай хэрэгжүүлж, үр дүнг тооцож, нийтэд ил тод мэдээлж ажиллах

Аймгийн Засаг дарга П.Лхагважавт:

1. Барилга байгууламж, дэд бүтцийн зураг, төсвийн тооцооллын уялдаа, үнэн зөв байдалд хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг тодорхойлох
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний сумдаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, үр дүнг тооцож ажиллах

Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Г.Базарт:

1. Хөвсгөл аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-ийн орлогыг шилжүүлэхдээ аймгийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу санхүүжүүлэх



Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Оюунтуяад:





1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний сумдаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, үр дүнг тооцож, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж ажиллах
2. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөх ажлын хэсгийн санал дүгнэлтийг ил тод мэдээлж ажиллах
3. Удирдлагын мэдээллийн системд ОНХС-ийн ТАХ-ний мэдээллийг бүрэн оруулж ажиллах



Сумдын Засаг дарга нарт:

1. Малын тоо толгойн албан татварыг үндэслэлтэй төлөвлөж, ОНХС-ийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг бүрэн дайчлан ажиллах
2. ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн мэдээллийг Удирдлагын мэдээллийн системд үнэн зөв, иж бүрэн мэдээлэх.
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний тусгай нөхцөлөөр чанарын баталгаат хугацааны барьцаа, гэрээний хугацаа хэтэрсэн тохиолдолд үүсэх харилцаа, алдангийн хувь хэмжээний талаар тодорхой тусгаж өгөх
4. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний худалдан авах ажиллагааг тухайн жилийн төсөв баталсан даруйд эхлүүлэх

Холбогдох байгууллагын санал:

Санал ирүүлсэн байгууллага	Санал	Санал шийдвэрлэсэн байдал
Аймгийн ИТХ	<p style="text-align: center;"> ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: (976) 70382764 Факс: (976) 70382554 Цахим шуудан: aimgin@khural.gov.mn Цахим хуудас: khovsgol.khural.mn</p> <p style="text-align: center;">2024.07.05 № 02/155 танай _____ -ны № _____ -Т</p> <p style="text-align: center;">Г ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</p> <p>“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.</p> <p>Тайлангийн төсөлд хүргүүлэх санал байхгүй болно.</p> <p style="text-align: center;"> Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал Удирдлагын хэлтэс Нарийн бичгийн дарга Насанбуян Төмөрхуяг 2024-07-05 15:31:08</p>	Санал ирүүлээгүй.
Аймгийн Засаг дарга	<p style="text-align: center;"> МОНГОЛ УЛС ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001 Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn Цахим хуудас: www.khovsgol.gov.mn</p> <p style="text-align: center;">2024.07.04 № 1/278 танай _____ -ны № _____ -Т</p> <p style="text-align: center;">ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</p> <p>“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллана. Тайлангийн төсөлтэй холбоотой санал үгүй болно.</p> <p style="text-align: center;"> П.ЛХАГВАЖАВ</p> <p style="text-align: right;">6713021104</p>	Санал ирүүлээгүй.

<p>Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ</p>	<p style="text-align: center;"> ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 3303, Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn Цахим хуудас: www.khovsgol.gov.mn <u>2024.07.05</u> № <u>6/1275</u> Танай _____ -ны № _____ -г</p> <p style="text-align: center;">ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</p> <p>“Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллана. Тайлангийн төсөлтэй холбоотой санал үгүй болно.</p> <p style="text-align: center;">ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ОЮУНТУЯА</p> <p style="text-align: right; color: blue;">6712090893</p>	<p>Санал ирүүлээгүй.</p>
<p>Аймгийн ОНӨГ</p>	<p style="text-align: center;"> ХӨВСГӨЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР АЗДТГ-ын байр А корпус 1 давхар 8 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 2348, факс: 7038 2348 Цахим шуудан: Umchingazarg@khs.gov.mn Цахим хуудас: http://umch.khs.gov.mn <u>2024.07.05</u> № <u>1/263</u> Танай _____ -ны № _____ -г</p> <p style="text-align: center;">ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА</p> <p>Танай 2024 оны 01/415 тоот албан бичгээр ирүүлсэн орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнгийн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Тайлангийн төсөлтэй холбоотой саналгүй болно.</p> <p style="text-align: center;">ДАРГА  Х.ЦЭНД-АЮУШ</p> <p style="text-align: right; color: blue;">6712030311</p>	<p>Санал ирүүлээгүй.</p>

<p>Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ</p>	 <p>Хөвсгөл Барилга Захиалагчийн Хяналтын Төв ААТҮГ</p> <p>Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 3353</p> <p>2024.07.04 № 01/193 танай _____-ны № _____-т</p> <p>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</p> <p>"Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн, үр нөлөө" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.</p> <p>Дээрх тайлангийн төсөлтэй холбоотой тухайлсан саналгүй болно.</p> <p>ЗАХИРАЛ Х.ДАВААСҮРЭН</p>	<p>Санал ирүүлээгүй.</p>
<p>Мөрөн сумын Засаг дарга</p>	 <p>Хөвсгөл Аймаг дахь Төрийн Аудитын Газарт</p> <p>Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 4316, Цахим шуудан: moronsum@khs.gov.mn, Цахим хуудас: http://moron.khs.gov.mn</p> <p>2024.07.05 № 01/683 танай 2024.07.04-ны № 01/417 -т</p> <p>ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</p> <p>"Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.</p> <p>Тайлангийн дүгнэлттэй холбоотой санал байхгүй болно.</p> <p>Хавсралт хуудастай.</p> <p>Х.ТАЙВАНБАЯР</p> <p>6712030890</p>	<p>Санал ирүүлээгүй.</p>

Зөрчлийн нэгтгэл:

/Сая.төгрөг/

№	Илэрсэн зөрчлийн		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Утга	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д шилжүүлэх орлогыг аймгийн Засаг даргын баталсан хуваарийн дагуу шилжүүлээгүй байна.	-					1	-
	Малын тоо толгойн албан татварыг 161.9 сая төгрөгөөр дутуу төлөвлөсөн.	-					1	-
2	“орон нутгийн хөгжлийн сан”-ийн саналыг цахимаар авах зорилготой “онхс” гар утасны аппликейшнийг ашиглан иргэдийн саналыг цахимаар авах хэлбэрээр аваагүй байна.	-					1	-
3	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлсэн жагсаалтад тусгагдаагүй иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл арга хэмжээг Тариалан, Тосонцэнгэл сумдын ИТХ баталж хэрэгжүүлсэн байна	162.4					1	162.4
4	Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг тодорхой чиг үүргээ хэрэгжүүлсэн боловч “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.4 ^[1] , 7.7 ^[2] -д заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.	-					1	-
5	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 ^[3] “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3 ^[4] -т заасан шаардлагыг хангаагүй төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн бөгөөд Хөвсгөл аймгийн орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах” гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмж ^[5] -ийг хэрэгжүүлээгүй байна.	2,664.4			1	2,664.4		
6	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 2,345.4 сая төгрөгийн төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг баталсан байна.	-			1	-		
7	Аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлсэн төсөл, арга					0		

	хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна.							
8	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний ХАА-г оройтуулж зохион байгуулснаас тухайн ажил ондоо багтаж хэрэгжээгүй байна.	0					1	0
9	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд чанарын баталгаа, гэрээний хугацаа, алдангийн талаар тодорхой тусгаж өгөөгүй, тухайн ажлыг хүлээлгэн өгснөөс хойш чанарын баталгаатай холбоотой үүсэх харилцаа тодорхойгүй нөхцөлтэй байна.	0					1	0
10	“Цагаан-Уул Могойн голын 35кВ-ын ЦДАШ-н засвар арчлалт” /Аймгийн ОНХС/ - гүйцэтгэгч Бошголсон ХХК нь тус ажлын машин механизм, ажиллах хүчийг Хөвсгөл Эрчим ХХК-аар гүйцэтгүүлсэн боловч холбогдох 19.4 сая төгрөгийн зардлыг тус компанид шилжүүлээгүй, Хөвсгөл эрчим хүч ХХК авлагаар тайлагнаагүй байна.	19.4	1	19.4				
11	Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн "Эрдмийн далай цогцолбор сургуулиас Номын өргөө дэлгүүр хүртэл гэрэлтүүлэг, явган замын тохижилт" төсөл арга хэмжээний явган зам нь хэмжээ зураг төсөвт заагдсан хэмжээнээс 179 м2 дутуу хийгдсэн байхад ажлыг хүлээж авч, санхүүжилтийг бүрэн олгосон байна.	6.6	1	6.6				
12	Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн Ухаалаг худгийн тохижилтын ажил төсөл арга хэмжээний зураг төсөвт заасан Долоогоно 3 ширхэг, Агч мод 3 ширхэг, Нарс мод 6 ширхэг суулгаагүй байна.	0.8					0.8	
13	Мөрөн сумын 9,11,12-р баг хөгжлийн төвийн урд байрлах хүүхдийн тоглоомын талбайн тохижилт төсөл арга хэмжээнээс ажлын даалгаварт заасан, талбайн тэмдэг тэмдэглэгээг хийгээгүй, талбайн хажууд 2 ширхэг	6.6			1		6.6	

	хогийн сав байршуулаагүй байхад захиалагч ашиглалтад хүлээн авсан байна.						
14	Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөлтийн шаардлага хангаагүй ТАН өргөн мэдүүлсэн.	777			1	777	
15	Мөрөн сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАН-үүдийг зураг төсвийн дагуу хүлээн аваагүй, баримт бичгийг дутуу бүрдүүлсэн.	0			1	0	
16	Галт сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн 4 цэгт шинээр гаргасан худгийн зураг төсөвт тусгагдсан худаг дотор байршуулах 1.5 метр куб хэмжээтэй цэвэр усны нөөц "нерж" савны оронд 1м3 багтаамжтай хуванцар савыг худаг тус бүрд байршуулсан байхад хүлээн авсан байна	6			1	6	
17	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 424.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг ашиглаагүй, 305.4 сая төгрөгийн ХО хадгалалтын горим алдагдсан. Аймаг сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон 3,474.0 сая төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнаагүй байна.	4,203.9			1	4,203.9	
18	Захиалагч, зураг төсөл зохиогч байгууллагаас барилга угсралтын ажлын явцад хяналт хийх давтамж бага хяналтаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг эргэж шалгахгүйгээс зураг, төсөвт тусгагдсан ажил бүрэн хийгдээгүй барилгыг улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан байна	179.9			1	179.9	
19	Барилга байгууламж, дэд бүтцийн зураг, төсвийн тооцооллын уялдаа, үнэн зөв байдалд хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэх албан хаагч тодорхойгүй байна.						1
20	Сумдын ИТХ нь 2023 оны ОНХС-аар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах чиг үүргийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлж ажилласан боловч хяналтын үр дүнг тооцож,	0					1 0

	нийтэд ил тод мэдээлэх ажил хангалтгүй байна							
21	Аудитад хамрагдсан аймаг, сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хүрээнд хийгдсэн захиалагчийн хяналт хангалтгүй, дүгнэлт, тэмдэглэлд ажлын явц, гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй тусгадаггүй, аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргээ хангалтгүй хэрэгжүүлж ажилласан байна.	0		1	0			
22	Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.	0		1	0			
23	Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 68 ТАХ-ийн мэдээллийг УМС-д зөрүүтэй мэдээлсэн байна.	1,495.1				1	1,495.1	
24	Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 23 ТАХ-ийн мэдээллийг УМС-д зөрүүтэй мэдээлсэн байна.	1,283.1				1	1,283.1	
25	ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний сумдаас ирүүлсэн тайланг нэгтгэн дүгнэж, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймгийн Засаг даргад танилцуулж ажиллах	0				1		
НИЙТ ДҮН		10,804.8	2	26.0	10	7,838.6	12	2,940.2

Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний жагсаалт

Хавсралт №1

№	ТАХ-ний нэр	Зураг, төсөв, ажлын даалгавар, техникийн тодорхойлолт боловсруулсан огноо	Төсөвт өртөг /сая.төг/
Аймгийн ОНХС			
1	"Эрүүл шүд Эрүүл хүүхэд" арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Техникийн тодорхойлолт 2023.01.18	140.0
2	Эхийн амрах байр барих /Баянзүрх сум/	Зураг төсөв 2023 он	60.0
3	Тээлийн амны ногооны талбайн үерийн далангийн их засвар /Тосонцэнгэл сум/	Зураг төсөв 2023 он	70.0
4	Бага оврын усны машин худалдан авах /Ханх сум/	Техникийн тодорхойлолт 2023.07.31	70.0
5	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төвд тоног төхөөрөмж худалдан авах /Мөрөн сум/ гүйцэтгэгч сонгох багц-4 оймс бээлий нэхэх машин нийлүүлэх	Техникийн тодорхойлолт 2023.08.14	180.0
6	Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих төвд тоног төхөөрөмж худалдан авах /Цагааннуур сум/ Багц-1 хүнсний тоног төхөөрөмж нийлүүлэх	Техникийн тодорхойлолт 2023.04.03	180.0
7	Хөвсгөлийн бренд бүтээгдэхүүнийг сурталчлах "Хөвсгөлд үйлдвэрлэв" борлуулалтын нэгдсэн төв, Бренд бүтээгдэхүүн борлуулах цэг байгуулах /Тосонцэнгэл сум/	Зураг төсөв 2023 он	100.0
8	Хатгал тосгонд стандартын шаардлага хангасан ундны усны худаг гаргах	Зураг төсөв 2023 он	60.0
9	Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх, засвар шинэчлэлт хийх /Мөрөн сум/	Зураг төсөв 2023 он	100.0
10	Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх /Рэнчинлхүмбэ сум/	Зураг төсөв 2023 он	100.0
11	50 ковш худалдан авах /Галт сум/	Техникийн тодорхойлолт 2023.01.06	170.0
12	Хог зөөвөрлөх пункертэй машин худалдан авах /Хот тохижилт үйлчилгээний төв/	Техникийн тодорхойлолт 2023.02.02	150.0
13	Хог зөөвөрлөх машин худалдан авах /Тариалан сум/	Техникийн тодорхойлолт 2023.01.10	100.0
14	Гэр хороололд "Жорлонгоо өөрчилье" төслийн зөвлөх үйлчилгээ авах, нүхэн жорлонгийн тоог бууруулах загвар хийлгэх	Ажлын даалгавар 2023.01.20	20.0
15	Хог зөөвөрлөх машин худалдан авах /Жаргалант сум/	Техникийн тодорхойлолт 2023.01.10	90.0
16	"Хоггүй Хөвсгөл" төслийн хүрээнд хог ангилан ялгах сав худалдан авах	Техникийн тодорхойлолт 2023.03.13	200.0
17	Аялал жуулчлалын бүс, зам дагуу стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барих ажил эхлүүлэх /Их-уул, Мөрөн сумдад/	Зураг төсөв 2023 он	240.0
18	6-р баг 12 дугаар багийн замын уулзварын ус зайлуулах хоолойг засварлах /Мөрөн сум/	Зураг төсөв 2023 он	90.0
19	Дулааны шугамын өргөтгөл /Цэцэрлэг сум/	Зураг төсөв 2023 он	77.5
20	Шаардлагатай цэгүүдэд хяналтын камерын тоог нэмэгдүүлж, шинэчлэх. /Мөрөн сум/	ТТ 2023.06.30	180.0
21	Хөвсгөл аймгийн нисэх онгоцны буудлыг жуулчдад зориулж тохижуулах ажил	Зураг төсөв 2023 он	50.0
22	Үүдний вистебулын Гонх засвар хийх /Нийтийн номын сан, Музей/	Зураг төсөв 2023 он	29.4
23	Өдөр өнжүүлэх өрөөний тохижилтын засвар /Аймгийн Засаг даргын Тамгын газар/	Зураг төсөв 2023 он	28.5
Дүн			2,345.4
Мөрөн сумын ОНХС			
1	9, 11, 12 –р баг хөгжлийн төвийн урд байрлах хүүхдийн тоглоомын талбайн тохижилт /Мөрөн сум/ ажлын даалгавар	Ажлын даалгавар 2023.04.16	30.0
2	Төв садны засвар тохижил	Зураг төсөв 2023 он	80.0

3	Ухаалаг худгийн тохижилтын ажил	Зураг, төсөв 2023.04.05	36.0
4	Эрдмийн далай цогцолбор сургуулиас номын өргөө хүртэлх явган зам, гэрэлтүүлгийн тохижилт	Зураг төсөв 2023 он	173.0
5	9,12 дугаар хорооны босоо тэнхлэгийн авто замын дагуу гэрэлтүүлэг явган замын тохижилт	Зураг төсөв 2023 он	353.0
6	Өвс тэжээлийн нөөц бэлтгэх	Ажлын даалгавар 2023.01.25	48.0
7	2,3 дугаар хорооны нарийн гудамжны тохижилт /хавчиг/	Ажлын даалгавар 2023.02.28	35.0
8	Зөөврийн ванн авах	Ажлын даалгавар 2023.05.08	22.0
Дүн			777.0
Нийт дүн			3,122.4

Нягтлан бодох бүртгэлд тусгаагүй хөрөнгө

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөл арга хэмжээний нэр	Дүн
1	Аймгийн ОНХС	"Уран дөш " Хүүхдийн зуслангийн менежмент, үйл ажиллагаа, орчин, нөхцөлийг сайжруулах.	30.0
2	Аймгийн ОНХС	Цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажлын дуусгалт /Мөрөн сумын 13 дугаар багт/	281.1
3	Аймгийн ОНХС	Цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажлын дуусгалт /Мөрөн сум "Хөх толгой" 10 дугаар багт/	198.23
4	Аймгийн ОНХС	Сумын төвийг шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлын дуусгалт /Ханх сумын төвийн гудамж талбайн гэрэлтүүлэг/	188.0
5	Аймгийн ОНХС	Агаарын цахилгаан шугам шинэчлэлт хийх /Мөрөн сум, 3, 5, 6, 14 дүгээр багууд/	414.2
6	Аймгийн ОНХС	"Хамгаалагдсан Хөвсгөл" арга хэмжээний хүрээнд Намнангийн арын постын ажлыг дуусгах	95.0
7	Аймгийн ОНХС	Сумын төв дотор зам тавих /Түнэл сум/	110.0
8	Аймгийн ОНХС	Хүүхэд залуучуудын гурвын эсрэг гурав сагсны талбай барих /Мөрөн сум 7-р баг/	69.8
9	Аймгийн ОНХС	Урандөш хүүхдийн зуслангийн байруудын их засвар	77.9
10	Аймгийн ОНХС	Тээлийн амны ногооны талбайн үерийн далангийн их засвар /Тосонцэнгэл сум/	70.0
11	Аймгийн ОНХС	Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх, засвар шинэчлэлт хийх /Мөрөн сум/	68.2
12	Аймгийн ОНХС	Цагаан-Уул Могойн голын 35кВ-ын ЦДАШ-н засвар арчлалт	104.2
13	Аймгийн ОНХС	Цахилгааны хангамжийг сайжруулж 15/0.4кВт дэд станц барих, 0.4 кВт-ын шугам шинэчлэх /Улаан-Уул сум/	114.0
14	Аймгийн ОНХС	Сумын төвийн шаардлага хангасан гэрэлтүүлэгтэй болгон аюулгүй байдлыг хангах ажлыг үргэлжлүүлэх /Рэнчинлхүмбэ сум/	84.2
15	Аймгийн ОНХС	Сумын төвийн дотор зам засвар, ус зайлуулах хоолойн ажлыг эхлүүлэх /Жаргалант сум/	269.2
16	Аймгийн ОНХС	Сумын төвийн хайрган хучилттай 3.5 км авто зам барих /Алаг-Эрдэнэ сум/	289.7
17	Аймгийн ОНХС	Хог зөөвөрлөх машин худалдан авах /Тариалан сум/	87.5
18	Жаргалант сумын ОНХС	Жаргалант сумын зам засвар	153.0
19	Цэцэрлэг ОНХС	Нүүрс тээврийн хүнд даацын машин	60.0
20	Цэцэрлэг ОНХС	Могойн бага сургуулийн дотуур байранд хүнсний агуулах барих	10.0
21	Аймгийн ОНХС	Бүрэнхаан сургуулийн баруун талын хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх / Сод Эрдэм ЕБСургуулийн баруун тал 1.106 метр хатуу хучилттай зам барих/	700.0
НИЙТ			3,474.0



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 91/22720648/ХӨА -
2024/26-20 - ЦТА - ГА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн “Цагаан-Уул Могойн голын 35кВ-ын ЦДАШ-н засвар арчлалт” төсөл арга хэмжээг “Бошголсон” ХХК гүйцэтгэж санхүүжилтийг 100 хувь авсан байхад Хөвсгөл Эрчим хүч ХХК тус ажлын машин механизм, ажиллах хүч, тээврийн зардалд 19,449,208.0 (арван есөн сая дөрвөн зуун дөчин есөн мянга хоёр зуун найм) төгрөгийг ямар нэгэн гэрээ хэлцэлгүйгээр давхардуулан зарцуулсан байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн “6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Давхардуулан зарцуулсан 19,449,208.0 (Арван есөн сая дөрвөн зуун дөчин есөн мянга хоёр зуун найм) төгрөгийг “Бошголсон” ХХК-иас гаргуулж Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг “Бошголсон” ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Цэрэндоржид хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

6724020327



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 92/2270848/ХГА-

Мөрөн сум

2024/26-20-ИТА-ГА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн "Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө" гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн "Эрдмийн далай цогцолбор сургуулиас Номын өргөө дэлгүүр хүртэл гэрэлтүүлэг, явган замын тохижилт" төсөл арга хэмжээний гүйцэтгэгч "Ти Эйч Ти Эн эрчим" ХХК нь зураг төсөвт заагдсан хэмжээнээс 6,607,121 (Зургаан сая зургаан зуун долоон мянга нэг зуун хорин нэг) төгрөгийн 179 м2 явган замыг дутуу гүйцэтгэсэн байхад санхүүжилтийг бүрэн авсан байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т "Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна", Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 4.8.12-т "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно" дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дутуу гүйцэтгэсэн ажлын санхүүжилт 6,607,121 (Зургаан сая зургаан зуун долоон мянга нэг зуун хорин нэг) төгрөгийг гүйцэтгэгч "Ти Эйч Ти Эн эрчим" ХХК-аар гаргуулж Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 01-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг "Ти Эйч Ти Эн эрчим" ХХК -ийн гүйцэтгэх захирал Д.Энхтүвшинд хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

6724020322



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 84/2270648/ХӨА-
2024/26-20 - ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй, төсөвлөлтийн шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтыг батлан хэрэгжүүлээгүй байна
2. Өмнөх аудитаар өгсөн аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавих болон төсөвлөлтийн шаардлага хангасан хөрөнгө оруулалтыг батлах гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.2.2 “Тухайн шатны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цаашид орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд хяналт тавьж, төсөвлөлтийн шаардлагад нийцсэн хөрөнгө оруулалтыг батлан, аудитын шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга (Г.Мөнгөнхуяг)-т даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

6724070334



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 25/2270648/ХӨА-

Мөрөн сум

2024/26-20-ШТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Аймгийн Засаг даргын 2022 оны А/165 дугаар захирамжаар байгуулсан ажлын хэсэг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд мэдээлэх, Иргэний танхимаар нээлттэй зохион байгуулаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 7.4 “Аймаг, нийслэлийн Засаг дарга ажлын хэсгийн санал, дүгнэлтээр баталгаажсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан танилцуулна.”, 7.5 “Урьдчилсан жагсаалтыг аймаг, нийслэлийн Иргэний танхимаар дамжуулан, нийтэд зар мэдээ хүргэсний үндсэн дээр нээлттэй хэлэлцүүлгийг жил бүрийн 7 дугаар сард багтаан зохион байгуулна.”-д заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний саналыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд олон нийтэд мэдээлэх, Иргэний танхимаар нээлттэй зохион байгуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг аймгийн Засаг дарга (П.Лхагважав)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

6724070322



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 86/2270648/ХӨА -
2024/26-20-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл арга хэмжээний үр дүнд бий болсон 3,473,973,000 (гурван тэрбум дөрвөн зуун далан гурван сая есөн зуун далан гурван мянга) төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн хадгалалт хамгаалалтад тавих хяналт алдагдсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2. “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”-ыг нягтлан бодох бүртгэлд хөтлөх, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.4.6. “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон энэ журамд заасны дагуу шийдвэрлэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон 3,473,973,000 (гурван тэрбум дөрвөн зуун далан гурван сая есөн зуун далан гурван мянга) төгрөгийн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгаж, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж ажиллан, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга (Х.Цэнд-Аюуш)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

6724070325



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 01 сарын 05 өдөр

№ 87/2210648 /ХӨА -
0024/26-20-ШТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

1. Аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс нь 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ үнэлгээ хийгээгүй байна.
2. Өмнөх аудитаар өгсөн “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц үр дүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж нийтэд ил тод мэдээлэх” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.5. “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Журам шинэчлэн батлах тухай” 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаал “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга (Д.Нямжав)-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

6724020326



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 88/2240618/ХӨА-

Мөрөн сум

2024/26-20-ШТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн “Тээлийн амны ногооны талбайн үерийн далангийн их засвар” төсөл арга хэмжээний зураг, төсөвт заасан ажлыг бүрэн гүйцэтгээгүй,
2. “Уран дөш хүүхдийн зуслангийн хуучин 6 шовгорыг засварлах” төсөл арга хэмжээний ажлын явцад зураг төсөв өөрчлөгдсөн гэх боловч зохиогчоор өөрчлөлтийн дүгнэлт гаргуулаагүй,
3. “Урандөш хүүхдийн зуслангийн менежмент орчны тохижилт сайжруулах” төсөл арга хэмжээний зураг төсөвт заагдсан ажил бүрэн хийгдээгүй

Дээрх ажлуудыг батлахад зураг төсөв нь зөрүүтэй, зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байхад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа “Барилга захиалагчийн хяналтын төв” ААТҮГ-ийн холбогдох албан тушаалтан ашиглалтад хүлээн авах дүгнэлт гаргасан байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.5 “барилгын ажлын үе шат бүрд зохиогчийн хяналт хийлгэж, хөндлөнгийн лабораторийн шинжилгээгээр материал, хийц, бүтээц, эдлэхүүний чанар, аюулгүй байдлын техникийн үзүүлэлтүүдийг тодорхойлуулж, холбогдох зардлыг хариуцах” Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх төсөл арга хэмжээний гүйцэтгэлд дахин хяналт хэрэгжүүлж гүйцэтгэлийн төсвийг гаргаж дүгнэлт хийж, зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах, биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг аймгийн Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ-ийн дарга (Х.Даваасүрэн), ерөнхий инженер (А.Ганзоригт) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

6724030311



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 39/2270648/АГА-

Мөрөн сум

2024/26-20-ИТА -ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд Барилга захиалагчийн хяналтын төв ААТҮГ нь захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй ажлыг хүлээн авч дүгнэлт гаргасан, аймаг сумдын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6. “Энэ хуулийн 32.1.5, 33.1.23-т зааснаас бусад барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах” Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 5.3.1. “Захиалагч болон захиалагчийг төлөөлж захиалагчийн техник, технологийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹-т ирүүлэхийг Барилга захиалагчийн хяналтын төвийн дарга (Х.Даваасүрэн), ерөнхий инженер (А.Ганзоригт) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

6724030341



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 07 сарын 05 өдөр

№ 90/2270648/ХӨА -

Мөрөн сум

2024/26-20-ШТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Мөрөн сумын засаг дарга нь 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төлөвлөлтийн шаардлага хангаагүй нийт 777,000,000 (долоон зуун далан долоон сая) төгрөгийн 8 төсөл арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.3 “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон байх;” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төлөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөсөн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр), Засаг даргын тамгын газрын дарга (Г.Нэргүй) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

6724030330



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 91/2270648/ХӨА-

Мөрөн сум

2024/26-20-ШТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Мөрөн сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн “9, 11, 12 дугаар Баг хөгжлийн төвийн урд байрлах хүүхдийн тоглоомын талбайн тохижилт”, “Ухаалаг худгийн тохижилт” төсөл арга хэмжээг Мөрөн сумын Засаг даргын 2023 оны А/200, А/171 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байхад хүлээн авч санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх төсөл арга хэмжээний дутуу ажлыг зураг төсөвт заасны дагуу гүйцэтгэгч аж ахуйн нэгжээр хийлгэж, биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр), Засаг даргын тамгын газрын дарга (Г.Нэргүй) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АХЛАХ АУДИТОР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас: 70384043

672403012



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 92/2270648/ХӨА -
2024/26-20 -ИТА-ГА

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

Галт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн “4 цэгт шинээр худаг гаргах” төсөл арга хэмжээг зураг төсөвт заасан тус бүрийн үнэ 1,500,00 (нэг сая таван зуун мянган) төгрөг нийт 6,000,000 (Зургаан сая) төгрөгийн үнэ бүхий 4 ширхэг цэвэр усны нөөцийн нерж савыг байршуулаагүй байхад ажлыг гүйцэтгэлийг бүрэн гүйцэтгэсэнээр хүлээн авсан байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээрх төсөл арга хэмжээний дутуу ажлыг зураг төсөвт заасны дагуу гүйцэтгэгч аж ахуйн нэгжээр хийлгэж, биелэлтийг 2024 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Галт сумын Засаг даргын орлогч (Л.Цэнд-Аюуш), Санхүү албаны дарга (А.Алтанцацрал) даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

6724030318



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 07 сарын 05 өдөр

№ 93/2270642/ХВА -

Мөрөн сум

2024/26-20-ШТА -ГА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. **Үүнд:**

1. Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн “9, 11, 12 дугаар Баг хөгжлийн төвийн урд байрлах хүүхдийн тоглоомын талбайн тохижилт” төсөл арга хэмжээг зураг төсөвт заагдсаны дагуу гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон,
2. Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн “Ухаалаг худгийн тохижилт” зураг төсөвт заагдсаны дагуу гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон,
3. Мөрөн сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжсэн “Эрдмийн далай цогцолбор сургуулиас Номын өргөө дэлгүүр хүртэл гэрэлтүүлэг, явган замын тохижилт” зураг төсөвт заагдсаны дагуу гүйцэтгээгүй байхад ашиглалтад хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Дээрх төсөл арга хэмжээнүүдийг Мөрөн сумын Засаг даргын 2023 оны А/171, А/200, А/250 дугаар тушаалаар баталсан ажлын хэсэг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүй байхад хүлээн авч санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т “Барилгын ажлын зөвшөөрөлд заасан нөхцөл, зураг төслийн дагуу гүйцэтгэснийг баталгаажуулан энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулна, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.2.2.4. “барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн буюу бүрэн санхүүжилтийн хүсэлт гаргах бөгөөд төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх мэдээллийг цахим системд баталгаажуулсан байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн

6724030336

алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Мөрөн сумын Засаг даргын 2023 оны А/171, А/200, А/250 дугаар тушаалаар баталсан ажлын хэсгийн гишүүдэд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Мөрөн сумын Засаг дарга (Х.Тайванбаяр), Засаг даргын тамгын газрын дарга (Г.Нэргүй) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

Г.ИЧИНХОРЛОО



¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043